

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

Журам шинэчлэн шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, 43 дугаар зүйлийн 2 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах журмыг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журам" батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/340 дугаар тушаалыг 2025 оны дүгээр сарын -ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалыг 2025 оны ... дүгээр сарын -ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

САЙД

Ж.ЧИНБҮРЭН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
... дугаар сарын ...-ны өдрийн тоот
тушаалын нэгдүгээр хавсралт

АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГИЙН ЖУРАМ (Төсөл)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлд ажилладаг ажилтны эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийг зохион байгуулах, хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Ажилтны эрүүл мэндийн үзлэг нь ажил, хөдөлмөртэй холбоотой эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг тодорхойлох, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдахаас болон ажилтны эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үйлдвэрлэлийн осол гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой.

1.3. Хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын харьяа мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага энэхүү журмыг хэрэгжүүлэхэд ажил олгогч, эрүүл мэндийн байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

1.4. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, ажилтны эрүүл мэндийн үзлэгийг хийхэд үндэсний эсхүл олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эмнэлзүйн удирдамж, мэргэжлийн аргачлал, стандартыг мөрдөж ажиллана.

Хоёр. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт

2.1. Ажил олгогч нь нь үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчинд хүргэж болзошгүй ажлын байрны нөхцөлд ажилладаг ажилтны эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг хэрэгжүүлнэ.

2.2. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт нь байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн үйл ажиллагааны нэг хэсэг бөгөөд ажлын байран дахь аюулыг арилгах, бууруулах анхдагч урьдчилан сэргийлэлтийг орлохгүй.

2.3. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт нь дараах үе шатаар хэрэгжинэ:

2.3.1. хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтад хамруулах шаардлагатай үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлтэй ажил,

мэргэжил /цаашид “эрсдэлтэй ажил, мэргэжил” гэнэ/-ийн жагсаалтыг ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшинд үндэслэн тодорхойлох;

2.3.2. эрсдэлтэй ажил, мэргэжилд ажиллах ажилтанд тавигдах эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт /цаашид “*эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт*” (*хавсралт 3.2*) гэнэ/-ийг ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагааны эрсдэл, ажил үүргийн онцлогоос хамааран тодорхойлох;

2.3.3. эрсдэлтэй ажил, мэргэжилд шинээр ажилд орох ажилтанд хийх эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн төлөвлөгөөг боловсруулах;

2.3.4. эрсдэлтэй ажил, мэргэжилд шинээр ажилд орох ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулан мэргэжлийн тохироог үнэлж, ажилд орох үеийн эрүүл мэндийн суурь үзүүлэлтийг хадгалах;

2.3.5. ажилтны ажлын байрны эрсдэл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэлийг үнэлж, эрүүл мэндийн хугацаат үзлэгийн төлөвлөгөөг боловсруулах;

2.3.6. ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулан эрүүл мэндийн эрсдэл, мэргэжлийн тохирооны үнэлгээ хийх, зөвлөмж өгөх;

2.3.7. шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн хугацаат үзлэгийн дүнд үндэслэн мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг баталгаажуулах, хөдөлмөр зохицуулалтыг хийх;

2.3.8. Ердийн өвчний хөдөлмөрийн чадвар алдалтын заалт үүссэн ажилтныг харьяа эрүүл мэндийн магадлалын зөвлөлд илгээх, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь болон хугацааг тогтоох, эрүүл мэндэд тохирсон ажил хөдөлмөр эрхлэх зөвлөмж өгөх;

2.3.9. хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтын үр дүнд үндэслэн ажилтны эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх байгууллагын хөдөлмөрийн эрүүл мэндийн үйл ажиллагааг төлөвлөх.

2.4. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтыг ажил олгогчийн томилсон эсхүл гэрээт хөдөлмөрийн эрүүл мэндийн эмч болон хөдөлмөрийн эрүүл ахуйч хариуцаж ажиллана.

2.5. Ажилтны эрүүл мэндийн үзлэг хийх эмч нарын багийг хөдөлмөрийн эрүүл мэнд (мэргэжлээс шалтгаалсан өвчин судлаач)-ийн эмч ахалж ажиллана.

2.6. Эрсдэлтэй ажил, мэргэжилд ажиллах ажилтанд тавигдах эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтыг тодорхойлоход хүлээн зөвшөөрөгдсөн эмнэл зүйн удирдамж, мэргэжлийн аргачлалыг ашиглаж болно.

2.7. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалт, эрүүл мэндийн үзлэгийн зохион байгуулахад оролцож буй мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллага мэргэжлийн ёс зүйг чанад мөрдөж, ялгаварлан гадуурхалаас ангид, хувь хүний нууц, нэр хүндийг хамгаалж ажиллана.

2.8. Ажилтны эрүүл мэндийн мэдээллийн баримт, өгөгдлийг найдвартай хадгалж, хамгаалах бөгөөд ажилтнаас таниулсан зөвшөөрөл авсны үндсэн дээр эрүүл мэндийн судалгаа, хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтын зориулалтаар ашиглаж болно. Хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтын зорилгоор боловсруулалт хийж, ажил олгогч, бусад холбогдох талд танилцуулахад хувь хүний мэдээллийг нууцалсан байна.

Гурав. Эрүүл мэндийн үзлэгийн төрөл, мэргэжлийн тохироо

3.1 Эрүүл мэндийн үзлэг нь ажилтны эрүүл мэндийг тандах, ердийн болон мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилготой. Эрүүл мэндийн үзлэг нь дараах төрлүүдтэй байна.

3.1.1 Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг: Ажилтан ажилд орохын өмнөх эрүүл мэндийн үзлэг бөгөөд тухайн ажил горилогч иргэн гүйцэтгэх ажил үүрэг, ажиллах орчин нөхцөлдөө эрүүл мэндийн хувьд тохирох эсэхийг (сэтгэл зүй болон бие махбодийн хувьд) тодорхойлно.

3.1.2 Эрүүл мэндийн хугацаат үзлэг: Ажил үүрэг эсхүл ажлын орчин нөхцөл нь ажилтны одоогийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа эсэх мөн тухайн ажилтны эрүүл мэндийн байдал нь тухайн ажлын байранд тохиромжтой хэвээр байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор ажил эрхлэх явцад тодорхой давтамжтайгаар явуулна.

3.1.3 Ажилд буцаж орох үеийн үзлэг: Эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас түр завсардсан, мэс засал осол гэмтэл болон бусад өвчлөлийн дараах, эмчилгээ бүрэн дууссаны дараа ажлын байранд эргэн гарахдаа бие махбодын хувьд ажилтан үндсэн ажил үүргээ гүйцэтгэхэд тохиромжтой эсэхийг тодорхойлох үзлэг. Тухайн үзлэгээр шаардлагатай тохиолдолд шат дараатайгаар эрүүл мэндэд тохирсон хязгаарлалт зөвлөмж өгнө.

3.1.4 Ажлын нөхцөл солих үеийн үзлэг: Ажлын нөхцөл, ажлын байр солих үеийн эрүүл мэндийн байдлыг үнэлнэ. Ижил ажлын байранд шилжиж ажиллах үед өмнөх үзлэгийн хугацаа 6 сараас дээш хугацаа өнгөрсөн тохиолдолд давтан үзлэгт орно. Ингэхдээ тухайн ажлын байр солих хүсэлт нь байгууллага болон ажилтны хүсэлтээр хийгдэх бөгөөд хэрэв тухайн ажилтанд ердийн өвчин болон мэргэжлээс шалтгаалах өвчний заалт үүссэн тохиолдолд ажил мэргэжлийн тохироог үнэлэхдээ өмнөх салбар эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр хөдөлмөрийн чадвараа алдсан хувь, хугацаа, шалтгааныг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цагийг богиносгох, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх асуудлыг төрөлжсөн мэргэшлийн эмч болон хяналтын эмчийн дүгнэлт, саналыг үндэслэн тогтоосон зөвлөмжийг тусгана.

3.1.5 Ажлаас гарах үеийн үзлэг: Ажилтан нь ажлаас гарах үеийн эрүүл мэндийн байдлыг баримтжуулах ба үзлэгийн баримт бичгийг ажилтан өөрөө хадгалах үүрэг хүлээнэ. Байгууллага ажлаас гарах үзлэгийг хийсэн ба ажилтанд баримт бичгийг хүлээлгэн өгсөн бүртгэл хөтөлнө.

3.2 Мэргэжлийн тохироо гэж ажилтан тухайн ажлын нөхцөлд болон ажил үүргийг хийж гүйцэтгэхэд эрүүл мэндээр тохирох эсэхийг эмчийн үзлэг, оношзүйн болон лабораторийн шинжилгээгээр тодорхойлохыг хэлнэ.

3.3 Мэргэжлийн тохирооны маргаантай тохиолдолыг мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага эцэслэн шийдвэрлэнэ. Ингэхдээ эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт болон хүлээн зөвшөөрөгдсөн эмнэл зүйн удирдамж, мэргэжлийн аргачлалыг ашиглана.

Дөрөв. Эрүүл мэндийн үзлэг

4.1. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийг төлөвлөх, мэргэжлийн тохироог үнэлэхэд тухайн ажлын байранд тавигдах “Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт”-ийг удирдамж болгоно.

4.2. Ажил олгогч нь эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн үр дүнг ажилтны ажилд орох үеийн эрүүл мэндийн суурь үзүүлэлт болгон хадгалж, хөдөлмөрийн эрүүл мэндийн тандалтад ашиглана.

4.3. Эрсдэлтэй ажил, мэргэжилд шинээр ажилд орох эсхүл эрсдэлтэй ажил, мэргэжлээс 6 сараас дээш завсарласан тохиолдолд эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдаж, мэргэжлийн тохироог үнэлүүлсэн байна.

4.4. Эрсдэлтэй ажил, мэргэжлээс эрүүл мэндийн шалтгаанаар завсардсан бол ажилд буцаж орох үзлэгт хамрагдаж, мэргэжлийн тохироог дахин үнэлүүлнэ.

4.5. Ажил олгогч нь эрсдэлтэй ажил, мэргэжлээр ажилладаг ажилтныг эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулах төлөвлөгөөг ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшнээс хамааран боловсруулж, хэрэгжүүлнэ.

4.6. Эрүүл мэндийн үзлэгийн нэгдсэн төлөвлөгөө нь дараах агуулгыг хамарсан байна:

4.3.1. эрүүл мэндийн ерөнхий үзлэг, шинжилгээний төрөл;

4.3.2. хөдөлмөрийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төрөл;

4.3.3. үзлэгийн давтамж.

4.7. Эрүүл мэндийн байгууллага нь ажил олгогчоос ирүүлсэн “Ажилтны эрүүл мэндийн урьдчилсан үзлэгийн төлөвлөгөө”-ний дагуу үзлэгийг зохион байгуулж, ажилтан бүрийн мэргэжлийн тохироог үнэлж, тайланг ердийн өвчин, мэргэжлээс шалтгаалах өвчин, нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд байх, нэмэлт шинжилгээ бүрдүүлж онош тодруулах, эрүүл мэндийн магадлалын зөвлөлөөр магадлуулж хөдөлмөр зохицуулалт хийх гэсэн ангиллаар өгнө.

**Тав. Мэргэжлээс шалтгаалсан өвчний оношилгоо,
хөдөлмөр зохицуулалт**

5.1. Эрүүл мэндийн үзлэгээр ажилтанд ердийн өвчний шалтгаанаар хөдөлмөр зохицуулалт хийх шаардлагатай бол ажилтны харьяаллын дагуу эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлд илгээн шийдвэрлүүлнэ.

5.2. Эрүүл мэндийн үзлэгээр мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн тохиолдолд үзлэгийг зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллага ажил олгогчид мэдэгдэнэ. Ажил олгогч, эрүүл мэндийн байгууллага хамтран ажилтныг мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллагад онош тодруулахаар илгээнэ. Ажил олгогч нь хөдөлмөр зохицуулалтыг мэргэжлээс шалтгаалсан өвчний салбар зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн хийнэ.

5.3. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага нь мэргэжлээс шалтгаалсан өвчний шинж тэмдэг илэрсэн ажилтны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээний тайлан, эмнэл зүйн үзлэг, шинжилгээнд үндэслэн шийдвэрлэж, хариуг эргэн ажил олгогч болон эрүүл мэндийн байгууллагад хүргүүлнэ. Шаардлагатай бол Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага нэмэлт эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, үнэлгээ хийнэ.

Тав. Тайлан, статистик

5.1 Ажилтны эрүүл мэндийн үзлэг зохион байгуулсан эрүүл мэндийн байгууллага ажил олгогчийн хамт мэргэжлээс шалтгаалах өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан төрийн байгууллагад мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилсан оношийн тохиолдол бүрийг оношлогдсон даруйд илгээнэ.

5.2. Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага нь мэргэжлээс шалтгаалсан өвчний оношийг нягталж, нэгдсэн бүртгэл мэдээллийг хөтөлнө.

5.3. Урьдчилан сэргийлэх бүх төрлийн эрүүл мэндийн үзлэг хийж байгаа эрүүл мэндийн байгууллагууд эрсдэлтэй ажлын байрны үзлэгийн мэдээг Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөл хариуцсан байгууллага руу явуулна.

5.4. Үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллага үзлэгийн дүгнэлтийг ажил олгогчид гаргаж өгнө.

Зургаа. Ажилтанд тавигдах шаардлага

6.1 Ажилтан ажил олгогчоос тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамрагдах үүрэг хүлээнэ.

6.2 Ажилтан ажлын байрны ХАБЭМ-ийн дүрэм журмыг сахиж, эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрүүл мэндийн байгууллагын заавар зөвлөмжийг баримталж, өөрийн эрүүл мэндээ хамгаалах үүрэг хүлээнэ.

6.3 Ажилтан “Ажил мэргэжлийн тохирооны дүгнэлт”-ийн дагуу ажил хөдөлмөр эрхэлнэ.

Долоо. Ажил олгогчид тавигдах шаардлага

7.1 Ажил олгогч нь ажилтныг хууль журамд заасан хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулах ажлыг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

7.2 Ажил олгогч нь холбогдох хууль, дүрэм, журмын дагуу шаардлагатай ажлын байран дээр хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

7.3 Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг эрүүл мэндийн үзлэг зохион байгуулахын өмнө үзлэг хийх эмнэлгийн багт танилцуулна.

7.4 Ажилтныг эрүүл мэндийн үзлэгийн дүгнэлтээр гарсан ажил мэргэжлийн тохироог үндэслэн тохирох ажлын байранд томилон ажиллуулна.

7.5 Ажилтанд ажлын байрны нөхцөлөөс хамааран зовуурь, өвчлөл илэрсэн үед үзлэгийн хугацаа, товлोल хараглзахгүйгээр эрүүл мэндийн үзлэг хийлгэнэ.

7.6 Ажилтны эрүүл мэндтэй холбоотой нууцлалыг хуулийн хүрээнд чандлан хадгална. Хэрэв ажилтан эрүүл мэндтэй холбоотой мэдээллийг хувийн нууцын тухай хуулийн хүрээнд хадгалж, шаардлагатай үед ажилтнаас урьдчилан “Таниулсан зөвшөөрөл”-ийг танилцуулж авна.

7.7 Эмнэлгийн байгууллагын зөвлөмжийн дагуу ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн мэдлэг, боловсрол олгох төлөвлөгөө гарган, хэрэгжүүлнэ.

Найм. Эрүүл мэндийн байгууллагад тавигдах шаардлага

8.1 Ажилтны эрүүл мэндийн үзлэг хийх эрүүл мэндийн байгууллага нь үзлэгийн төлөвлөлт, зохион байгуулалт, ажилтны эрүүл мэндийн эрсдэл болон мэргэжлийн тохироог үнэлэх, эрүүл мэндийн зөвлөгөө тусламж үзүүлэх мэргэжлийн цогц чадамжийг эзэмшсэн хөдөлмөрийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэшлийн эмчтэй байна.

8.2 Мэргэжлийн тохироог үйлдвэрлэлийн нөхцөл, ажлын байрны өртөлтийн талаар мэдлэгтэй, хөдөлмөрийн эрүүл мэнд, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр мэргэшсэн эмч хийнэ.

8.3 Эрүүл мэндийн байгууллага нь ажилтны эрүүл мэндийн үзлэгийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үзлэг, шинжилгээний төрлөөс хамаарч хөдөлмөрийн эрүүл мэнд болон бусад шаардлагатай төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг үзлэгийн багт ажиллуулна.

8.3. Ажил олгогч нь ажилтны эрүүл мэндийн үзлэгийн төлөвлөгөөгүй тохиолдолд үзлэг хийх эрүүл мэндийн байгууллага энэхүү журмын 2.3-д заасны дагуу үзлэгт хамрагдах ажилтны ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, эрсдэлийн түвшинд үндэслэн үзлэгийн төлөвлөгөөг боловсруулна.

8.4. Эрүүл мэндийн байгууллага нь эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай зохих нөхцөлүүдийг хангасан байна.

Хавсралтууд

- Хавсралт 1: Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн удирдамж лавлагаа
- Хавсралт 2.1: Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн маягт
- Хавсралт 2.2: Таниулсан зөвшөөрлийн хуудас
- Хавсралт 3.1: Мэргэжлийн тохироо үнэлэх шалгуур
- Хавсралт 3.2: Эрүүл мэндийн суурь шалгуур

Хавсралт 1. Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн удирдамж лавлагаа

Аюултай хүчин зүйлсийн өртөлт	Ерөнхий үзлэг дээр анхаарах асуумжууд	Тусгайлсан үзлэг сонгох	Үзлэгийн давтамж
Цулцанд нэвтэрдэг тоос, талст цахиурын тоос, нүүрсний тоос, асбестын өртөлттэй	Асуумжаар илрүүлэх өөрчлөлт: - Ханиалгах, цэр гарах зовиур 3 сараас дээш үргэлжлэх - ачаалалтай болон тайван үеийн амьсгал дутагдлын шинж - Өмнөх ажлын хөдөлмөрийн нөхцөл, тоос, хорт бодисын өртөлтийн түвшин - Өнөөгийн ажлын хөдөлмөрийн нөхцөл: ○ Өртөлт ихтэй ажлын үргэлжлэх хугацаа, давтамж ○ Ажлын байран дахь хурц үнэртэй цочроох, харшил үүсгэх нөлөөтэй бодисын өртөлт ○ Ажлын үеэр илэрдэг шинж тэмдэг (ханиах, цэр салсархаг шүүрэл гарах, амьсгаадах г.м) - Тамхины дэлгэрэнгүй асуумж: ○ тамхины хэрэглээ (огт татдаггүй, гарсан, татдаг) ○ тамхины төрөл (янжуур, цахилгаан, усан гаанс г.м.), ○ татсан хугацаа, жил	Ажилд авахын өмнөх үзлэгээр илрүүлэх өөрчлөлтүүд: - Уушги, зүрх судасны эрхтний ээнэгшлээ алдсан эмгэг - Гуурсан хоолойн архаг үрэвсэл, багтраа, уушги тэлэгдэх эмгэг - Архаг плеврит - Рентген зургаар уушги тоосжих өвчний шинж, соривжилт, зангилаа илэрсэн - Идэвхтэй эсвэл далд хэлбэрийн сүрьеэ - Цээжний хөндий, уушгинд мэс засал хийлгэснээс амьсгалахад бэрхшээл үүсгэдэг, Шим тэжээлийн дутагдалтай, биеийн жин хэвийн хэмжээнээс 30%-иар их (broca's formula) - Зүрхний үйл ажиллагааны дутагдалтай хавхлагын гажиг зэрэг эмгэг - Эмчилгээгээр хянах боломжгүй артерийн даралт ихсэлт Хугацаат үзлэг: - МШӨ ХЭМ-ийн эмч, уушгины эмчийн үзлэг - Зүрх судасны үзлэг - Спирометрийн сорил - Цээжний рентген зургийг 35*43 см хэмжээтэй (компьютер томограф шаардлагатай үед) - Цээжний рентген зургийг ОУХБ-аас гаргасан Пневмокониозын радиологийн олон улсын ангиллын дагуу уншина.	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - Өртөлтийн түвшин ЗДХ-нээс хэтэрсэн (өндөр, ноцтой эрсдэлтэй) - 12 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 50-99%-тай тэнцүү (дунд эрдсэлтэй) - 24 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 10-49%-тай тэнцүү (бага эрдсэлтэй) - 36 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 10%-иас бага (эрдсэлгүй) – үзлэг шаардлагагүй Ажлын байр солих үзлэг Хугацаат бус үзлэг: - Амьсгал, зүрх судасны эрхтний эмгэг үүсгэх үр дагавартай өвчнөөр удаан хугацаанд өвдсний дараа - Амьсгал, зүрх судасны эрхтний эмгэг үүсгэх үр дагавартай (ковид зэрэг) өвчнөөр богино хугацаанд өвдсний дараа - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Гагнуурын тоосонцор, хүнд металл: хар тугалга, мөнгөн ус, кадми, хүхэр		- Дээрх үзлэгийг хийнэ. Нэмэлтээр цус шээсэнд доорх биомониторингийн шинжилгээ хийх: ○ шээсэнд никель, хром зэрэг ○ цусанд хар тугалга, манган зэрэг ○ хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилтээр илэрсэн металлыг нэмж шинжлүүлж болно. ○ мэдрэлийн эрхтэн тогтолцооны үзлэг	

	○ өдөрт татдаг тамхины тоо - Гуурсан хоолойд нөлөөлөх эмний хэрэглээ (тэлэх, эсвэл нарийсгах үйлдэлтэй) - Сүрьеэ өвчний асуумж - Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийн асуумж		
Хавдар үүсгэх, мутаци үүсгэх, нөхөн үржихүйн хортой бодисууд: бензин, формальдегид, хром 6, винил хлорид	Асуумж: - Ханиах, цэр гарах - Амьсгаадах зовиур - Арьсны өвчин	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Арьсны эмгэг: экзем, хагарч хуурайшсан, харшилтай эсэх, тэжээлийн өөрчлөлт Хугацаат үзлэг : - биохимийн шинжилгээ, элэг бөөрний үйл ажиллагаа, Ig E, УЭТХ - шээсний шинжилгээ - Спирометрийн сорил - Цээжний рентген зураг 35*43 см	Шинээр ажилд орох үзлэг Хугацаат үзлэг: - 12 сар тутам Хугацаат бус үзлэг: - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Дэгдэмхий органик нэгдлүүд: бензин, толуен, этилбензин, ксилен (товчлол BTEX: benzene, toluene, ethylbenzene and xylene)	Асуумж: - Толгой өвдөх, эргэх, ядрах, дотор муухайрах, турах, согтууруулах ундаанд тэсвэргүй (хурдан согтох) - Өмнөх ажлын хөдөлмөрийн нөхцөл, уусгагч, үнэрт хорт бодисын өртөлтийн түвшин - Өнөөийн ажлын хөдөлмөрийн нөхцөл: ○ Өртөлт ихтэй ажлын үргэжлэх хугацаа, давтамж ○ Ажлын байран дахь хурц үнэртэй цочроох, харшил үүсгэх нөлөөтэй бодисын өртөлт ○ Ажлын үеэр илэрдэг шинж тэмдэг	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Өртөлтийн улмаас даамжирч болзошгүй мэдрэлийн эмгэг - Согтууруулах ундааны донтолт - Элэгний өвчин - Уушгины архаг бөглөрөлт эмгэг Хугацаат үзлэг: - Мэдрэлийн эрхтний үзлэг (урт хугацаанд мэдрэлийн эмгэг, согтууруулах ундааны донтолт) - Цусны дэлгэрэнгүй шинжилгээ - Элэгний үйл ажиллагааны шинжилгээ - Шээсний дэлгэрэнгүй шинжилгээ - Давтан үзлэгээс эхлэх биомониторингийн шинжилгээ хийх ○ Бүхэл цусанд толуол, ксилон ○ Эсвэл	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 50-иас хэтэрсэн тэнцүү (дунд, өндөр, ноцтой эрсдэлтэй) - 24 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 10-49%-тай тэнцүү (бага эрдсэлтэй) - 24 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 10%-иас бага (эрдсэлгүй) – үзлэг шаардлагагүй Хугацаат бус үзлэг: - Мэдрэл, цус, элэгний өвчнөөр удаан хугацаанд өвдсний дараа - Мэдрэл, цус, элэгний хүнд өвчнөөр богино хугацаанд өвдсний дараа - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд

	(ханиах, нүд, хоолой хорсох, нулимс гарах, толгой өвдөх, дотор муухайрах г.м)	Шээсэнд метилхиппурын хүчин тодорхойлох	Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Угаарын хий	Асуумж: - Зүрх судас, мэдрэл, сэтгэцийн эмгэг илрүүлэх асуулт - Толгой өвдөх, эргэх, ядрах, эрч хүчгүй болох, уур уцаартай болох, унтаарах, ой санамж муудах - Өмнөх ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин - Өнөөгийн ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин - Нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийн асуумж	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Зүрх судасны эмгэг хүндэрсэн (судас хатуурах г.м) - Уушгины хүнд эмгэг - Бамбай булчирхайн үйл ажиллагааны өөрчлөлттэй - Цус багадалттай - Төв мэдрэлийн тогтолцооны эмгэгтэй Хугацаат үзлэгээр: - Зүрх, судас, мэдрэл, үзлэг - Спирометрийн сорил - Честер степ тест - Хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт мониторингоор угаарын хийн өртөлт ЗДХ-ний 50%-иас хэтэрсэн бол биомониторингийн шинжилгээ хийх - Ажлын төгсгөл цусанд карбоксигемоглобин тодорхойлох	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 50-иас хэтэрсэн тэнцүү (дунд, өндөр, ноцтой эрдсэлтэй) - 12 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 10-49%-тай тэнцүү (бага эрдсэлтэй) - 24 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ний 10%-иас бага (эрдсэлгүй) – үзлэг шаардлагагүй Хугацаат бус үзлэг: - Зүрх судас, уушгины өвчнөөр удаан хугацаанд өвдсний дараа - Угаарын хийн хурц хордлогод орсны дараа - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Шуугиан	Асуумж: - Өмнөх ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин - Өнөөгийн ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин - Сонсгол хордуулах бодисын хэрэглээ (уусгагчид, дэгдэмхий органик нэгдэл) - Хобби (чихэвчний хэрэглээ, чанга дуутай мотоцикл, машины хэрэглээ .. гм) - Ажлын дараа чих шуугих, хүмүүсийн яриаг давтаж асуух, хөгжим зурагтын дууг чангалах	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Сонсголын босго хэмжээ зөвлөмж түвшнээс их тодорхойлогдсон - Дотор чихний эмгэгтэй - Сонсголын сувгийн экзема (эмчилгээнд үр дүн өгдөггүй), дунд чихний үрэвсэл, шүүрэлтэйгээс сонсгол хамгаалах хэрэгсэл хэрэглэх боломжгүй Хугацаат үзлэгээр: - Гадна чихний үзлэг, - Агаараар дамжуулалтай аудиометрийн сорил (1-6 кГц) - Эмчийн зөвлөгөө - Шаардлагатай ажилтанд хийх нэмэлт үзлэг: - Отоскопи	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - Өртөлтийн түвшин ЗДХ-ээс 3.1 ба түүнээс их дБ-ээр хэтэрсэн (ноцтой эрдсэлтэй) - 12 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ээс 0.1-3.0 дБ-ээр хэтэрсэн (өндөр эрдсэлтэй) - 24 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ээс 0.1-4.9 дБ-ээр хэтэрсэн бага (дунд эрдсэлтэй) - 36 сар тутамд - Өртөлтийн түвшин ЗДХ-ээс 5 дБ ба түүнээс бага (эрдсэлгүй) – үзлэг шаардлагагүй Хугацаат бус үзлэг:

	- Сонсгол хамгаалах хэрэгсэлийн асуумж	○ Веберийн сорил ○ Агаараар дамжуулалтай аудиометр (0.5-8кГц), ясаар дамжуулалттай аудиометр (0.5-4кГц эсвэл 6 кГц) ○ ASSR: auditory steady-state response (шаардлагатай бол) ○ Сонсгол хамгаалах хэрэгслийн хэрэглээний зөвлөгөө ○ Эмчийн зөвлөгөөний дагуу нэмэлт үзлэг	- Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд - Бэртэл гэмтэл, өвчний (тинусит, тархины гэмтэл г.м) улмаас сонсгол алдагдал тохиолдож байх магадлалтай Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Гарт дамжих доргион	Асуумж: - Цагаан гарны хам шинжийг илрүүлэх тусгайлсан асуумж асуух - Өмнөх ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин - Өнөөгийн ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин, орчны температур - Доргион үүсгэгч гар багажтай ажиллах давтамж, хугацаа	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Доорх эмгэгийн шинж тэмдэг илрэх Хугацаат үзлэгээр: - Доргионы шалтгаант яс болон үений гэмтлийг илрүүлэх зураг авч үений хэлбэр алдагдал, остеохондрозыг тодорхойлох - Цагаан гарны хам шинжийг Стокломын хэмжээсээр үнэлэх үзлэг - Капилляроскопи	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - Доргионы өртөлтийн түвшин ЗДХ-ээс 2 ба түүнээс олон дахин хэтэрсэн (ноцтой эрдсэлтэй) - 12 сар тутамд - Доргионы өртөлтийн түвшин ЗДХ-ээс 1-1.99 дахин хэтэрсэн (өндөр эрдсэлтэй) - 24 сар тутамд - Доргионы өртөлтийн түвшин ЗДХ-ний 50-99%-тай тэнцүү (дунд эрдсэлтэй) - 36 сар тутамд - Доргионы өртөлтийн түвшин ЗДХ-ний 49%-иас бага (эрдсэлгүй) – үзлэг шаардлагагүй Хугацаат бус үзлэг: - Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Бүх биед дамжих доргион, Гараар гүйцэтгэх ажлын эргономик	Асуумж: - Сүүлийн 12 сарын хугацаанд яс, булчин, холбогч эдийн сэргээн засах	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Ажлын нөхцөлөөс шалтгаалан хүндрэх яс булчин холбогч эдийн эмгэг Хугацаат үзлэгээр:	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг:

	физик эмчилгээнд хамрагдаж байсан эсэх - Яс булчин холбогч эдийн өвдөлт байгаа эсэх, энэ нь ажлын улмаас хүндрэх эрсдэлийг илрүүлэх, - Өмнөх ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин - Одоогийн ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин, орчны температур - Доргионтой машин тоног төхөөрөмжтэй ажиллах хугацаа, давтамж	- Суугаа болон алхаж буй байрлалд яс, булчин, холбогч эдийн эмгэгийг илрүүлэх үзлэг - Тулгуур эрхтний хөдөлгөөн болон үйл ажиллагааны үзлэг - Дээрх үзлэгээр анхаарах асуудал илэрвэл гарын авлагын дэлгэрэнгүй удирдамжийн дагуу нэмэлт үзлэг хийх	- Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Гадаа ажилладаг (Хүйтний ба Дулааны стресс, даралтын орчин, өндөрт ажиллах)	Асуумж: - Өмнөх болон одоогийн хөдөлмөрийн нөхцөл, ажлын талаар - Зүрх уушги, элэгний үйл ажиллагаа, бөөр, элэг, шээсний дамжуулах замын архаг эмгэгийг илрүүлэх асуулт	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Зүрх судасны архаг өвчин - Уушгины архаг бөглөрөлт эмгэг, гуурсан хоолойн багтраа, идэвхтэй эсвэл далд хэлбэрийн сүрьеэ - Архаг цус багадалт - Цусны эргэлтэд нөлөөлөхүйц арьсны эмгэг - Бүрэн эдгэрээгүй тархины гэмтэл - Бөөр, шээсний дээд, доод замын архаг өвчин - Элэгний үйл ажиллагааны үзүүлэлт - Нүдний катаракт - Ухаан алдалт (тодорхой эрүүл мэндийн асуудлаас шалтгаалсан) - Согтууруулах ундааны хэт их хэрэглээ, эм, мансууруурал бодисын хамааралтай - Таргалалт - Архаг олон дахих хандлагатай арьсны өвчин	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: - Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд Ажлаас гарахад үзлэг хийнэ.
Ядралтын эрсдэлтэй жолооч, оператор	Асуумж: - Ерөнхий анамнез, - Ажилтай холбоотой асуумж: Ажил үүрэг, ажлын цаг, анхаарал хандуулах хугацаа, хөдөлмөрийн нөхцөл, амралтын хугацаа	Ажилд авахын өмнөх үзлэгээр анхаарах өөрчлөлтүүд: - Зүрх судасны эмгэг: Зүрхний шигдээс, цус харвалт, зүрхний хэм алдагдал; - Мэдрэлийн эмгэг: Уналт таталт, ухаан алдах	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг:

	-	- Бодисын солилцооны эмгэг: Гипо-гипергликеми - Сэтгэцийн асуудал: сэтгэл зүйн төлөв байдал, эмгэг - Нойрны эмгэг, унтах үеийн амьсгалын тасалдал - Сэтгэцийн хэвийн бус байдал - Харааны үйл ажиллагааны дэлгэрэнгүй үзлэг - Сонсгол шалгах - Шээсний шинжилгээ	- Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сэргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд
Дэлгэц бүхий төхөөрөмжтэй ажилладаг (оффисын эргономик)	Асуумж: - Ач холбогдол бүхий намтарыг асуух - Анхаарал хандуулах эрүүл мэндийн асуудлын талаарх асуумж ○ Нүдний эмгэгийн шинж тэмдэг ○ Яс, булчин, холбогч эдийн тогтолцооны эмгэг ○ Мэдрэлийн эмгэг ○ Бодисын солилцооны эмгэг ○ Артерийн даралт ихсэлт ○ Урт хугацаанд ууж буй эмийн асуумж - Ажилтай холбоотой асуумж: ○ Ажлын байрны орчин ○ Ажил үүрэг ○ Ажлын цаг ○ ХЭМ-ийн сургалтад хамрагдсан байдал гэх мэт.	Ажилд авахын өмнөх болон хугацаат үзлэгээр дараах шинж тэмдгийг илрүүлэх үзлэг хийнэ: - Харааны дэлгэрэнгүй үзлэг: Холын болон ойрын хараа, астигматизм (шил зүүдэг бол шилтэй), орон зайн хараа - Яс булчин холбогч эдийн үзлэг	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: - Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн үед - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сэргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд

Аюулгүй ажиллагааны Категори 1, 2	Аюулгүй ажиллагааны категори 1,2,3,4 гэж яаж тодорхойлолт нэмнэ	Аюулгүй ажиллагааг хангах нэмэлт үзлэг: - ЗЦБ, зүрхний эхокардиографи хийх, зүрх судасны эмгэг: Зүрхний шигдээс, цус харвалт, зүрхний хэм алдагдал; - ЭЭГ: Мэдрэлийн эмгэг: Уналт таталт - Бодисын солилцооны эмгэг: Өлөн үеийн сахар - Сэтгэцийн асуудал: сэтгэл зүйн төлөв байдал, эмгэг - Sleep apное асуумж авна: Нойрны эмгэг, ажил дээрээ нойрмоглох, сонор сэрэмж алдах эрсдэлийг үнэлэх үзлэг	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: - Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн
Аюулгүй ажиллагааны Категори 3		Аюулгүй ажиллагааг хангах нэмэлт үзлэг: - Харааны чадавх, эмгэг; - Сонсголын түвшин; - Тулгуур эрхтний чадавх; - Мэдрэлийн эмчийн үзлэгээр шаардлагатай бол сэтгэл зүйн төлөв байдал, мэдрэлийн эмгэг зэрэг ажлын байран дээрээ аюулгүй байдлын анхааруулга, дохиог мэдрэхүйн эрхтнээрээ хүлээн авч, шаардлагатай үед аюултай орчноос зайлж холдох чадварыг алдагдуулах эрсдэлтэй эмгэг, асуудлыг илрүүлэх үзлэг	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн
Аюулгүй ажиллагааны Категори 4		Аюулгүй ажиллагааг хангах нэмэлт үзлэг: - Нэмэлт үзлэг шаардлагагүй	
Ионжуулагч болон ионжуулагч бус цацрагийн эх үүсвэртэй ажилладаг ажилтан		Нэмэлт үзлэг шинжилгээ: - цусны шинжилгээ - нөхөн үржихүйн үзлэг болон шинжилгээ-түрүү булчирхайн хэт авиа, эмэгтэйчүүдийн хэт авиа	Шинээр ажилд орох, хугацаат үзлэг: - Дозиметрын хэмжилтийг үндэслэнэ. - Эх үүсвэртэй ажилладаг цаг дээр үндэслэн үзлэгийн давтамжийг жилд нэгээс ихгүй тогтооно. Бусад эрүүл мэндийн үзлэгтэй хамт хийнэ. Хугацаат бус үзлэг: Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн

Талбар дээр ажилладаг ажилтан	Ажлын байрны асуумжаар сонгоно	Эрсдэлийн төрлөөс хамаарна, дээд хүснэгтүүдээс сонгоно.	Үзлэгийн хугацаа эрсдэлийн үнэлгээний зөвлөгөөг дагана.
Оффис ажилтан	Ерөнхий эрүүл мэндийн үзлэг	Нэмэлт үзлэг шинжилгээ: - гар шууны үзлэг заалтаар хийнэ. - Эргономик эрсдэл байгаа тул зовуурь илэрвэл захын мэдрэлийн ЭНГ хийж болно.	Ажилд шинээр ороход үзлэг хийнэ. Хугацаат үзлэг: - 3 жил тутамд Хугацаат бус үзлэг: - Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн үед - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд
Биологийн агентууд, бактери, вирус, мөөгөнцөр, шимэгч: сүрьеэ, гепатит В С, совид-19, боом	Ажлын байрны онцлог (эмнэлэг, лаборатори, малын ферм, био дээжийн төв гэх мэт) - Өмнөх халдварт өвчний түүх (сүрьеэ, гепатит, COVID-19, боом) - Вакцинжуулалтын түүх (BCG, HBV, COVID-19, бусад заавал хийлгэх вакцин) - Шинж тэмдэг: халуурах, ханиалгах, турах, шарлах, ядрах, арьс туурах	Нэмэлт үзлэг шинжилгээ: - иммунологийн тестүүд - Хугацаат үзлэгүүдийн түүхийг шалгана - Вакцинжуулалт хийлгэсэн асуумж авна - Сүрьеэгийн идэвхтэй хэлбэр: Манту сорил, цээжний зураг эсвэл IGRA - Архаг гепатит (В, С) ба элэгний дутагдал - Хамар, хоолойн арчдас /MRSA/	Шинээр ажилд орох үзлэг хийнэ Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: - Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн - Ажилтан өөрөө ажил хөдөлмөрийн нөхцөл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй гэж үзэж, хүсэлт гаргасан тохиолдолд
Пестицид болон газар тариалангийн химийн бодис	- Өмнөх ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин - Одоогийн ажлын хөдөлмөрийн нөхцөл, өртөлтийн түвшин	Нэмэлт үзлэг шинжилгээ: - Цусанд холинэстераза үзэх - мэдрэлийн тогтолцооны үзлэг болон шинжилгээ - Архаг мэдрэлийн тогтолцооны эмгэг (тархины гэмтэл, таталт, сэтгэцийн эмгэг) - Элэгний өвчин (гепатит, цирроз) - Бөөрний архаг өвчин - Хүнд харшлын эмгэг	Шинээр ажилд орох үзлэг хийнэ Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн

Хязгаарлагдмал орчин	- БЖИ<35, АГ<140/90 байх; - Архи, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээгүй байх - Нэг бүрийн хамгаалах хэрэгслийн асуумж - Архи, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээгүй байх - Уушги зүрх судасны эмгэгийн асуумж	Нэмэлт үзлэг шинжилгээ: - Нүдний харааны тест - 45-аас дээш насанд зүрхний эхо болон зүрхний ачаалалтай бичлэг - Сонсголын үзлэг шинжилгээ - Аэроб нөхцөлд ачаалал даах чадвар үзэх?? - Шээсэнд глюкоз илрээгүй байх- хяналтгүй чихрийн шижин өвчин - Спирометр	Шинээр ажилд орох үзлэг хийнэ Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн
Өндөрт ажиллах	- БЖИ<35, АГ<140/90; - Архи, сэтгэц нөлөөт бодисын хэрэглээгүй байх - Зүрх судасны өвчин: хэм алдагдал, бах, зүрхний дутагдал - Тархи толгойны гэмтэл - Мэдрэлийн талын эмгэг - Чихрийн шижин - Бөөрний эмгэг - Харааны эмгэг	Нэмэлт үзлэг шинжилгээ: - Нүдний харааны тест: харааны талбай хэвийн байх, диплопи, монокуляр хараа байгаа эсэхийг үзнэ. - 45-аас дээш насанд зүрхний эхо болон зүрхний ачаалалтай бичлэг - Сонсголын үзлэг шинжилгээ - Тэнцвэрийн сорил - Вегетатив хам шинжүүд: хөлрөх, дотор муухайрах, бөөлжих гэх мэт - ЭЭГ	Шинээр ажилд орох үзлэг Хугацаат үзлэг: - 12 сар тутамд Хугацаат бус үзлэг: Ажилтны эрүүл мэнд байдалтай холбогдуулан эмч үзлэг хийх зөвлөмж өгсөн
